

ЭРҮҮЛ МЭНДИЙН СТАТИСТИКИЙН САР ТУТМЫН МЭДЭЭЛЭЛ



2026 оны 05 сар

**Арвайхээр хот
2026 он**

Эрүүл мэндийн сар тутмын мэдээлэл 2026 оны 5 дугаар сар

Энэхүү товхимолын дэлгэрэнгүй мэдээллийг

www.ov.mohs.gov.mn цахим хуудаснаас татаж харна уу.

Өвөрхангай аймгийн Эрүүл мэндийн газар

Хяналт, шинжилгээ, үнэлгээ мэдээллийн хэлтсээс эрхлэн гаргав.

Шуудангийн хаяг: Арвайхээр хот, Өлзийтийн 1 дүгээр гудамж, 118 дугаар байр

E-mail: <http://www.ov.mohs.gov.mn/>, uvurkhangaiemg@gmail.com

Утас: 7032-2195, 99668055

Хянан тохиолдуулсан:

Я. Жаргал

Эрүүл мэндийн газрын Хяналт, шинжилгээ, үнэлгээ, мэдээллийн хэлтсийн дарга

Эмхэтгэсэн:

Д. Нацагням

Эрүүл мэндийн газрын Эрүүл мэндийн мэдээ, мэдээллийн асуудал хариуцсан мэргэжилтэн,
Статистикч их эмч

Гарчиг

ЭРҮҮЛ МЭНДИЙН СТАТИСТИК ҮЗҮҮЛЭЛТҮҮД	1
ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ,ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАРЫН ҮЗҮҮЛЭЛТ	2
1. Эх, хүүхдийн эрүүл мэнд	3
Төрөлт.....	3
Хүснэгт 1. Төрөлт, төрөх үед үзүүлсэн эмнэлгийн тусламж, хувиар	3
Зураг 1. Амьд төрсөн хүүхдийн тоо	4
1.2. Хүүхдийн эрүүл мэнд	4
Хүснэгт 2. Амьд төрсөн хүүхэд, эхийн тээлтийн хугацаа, хувиар	4
Хүснэгт 3. Тав хүртэлх насны хүүхдийн жингийн мэдээ, хувиар	5
Хүснэгт 4. Дархлаажуулалтын хамрагдалтын хувь, тухайн сараар	6
Хүснэгт 5. Дархлаажуулалтын хамрагдалтын хувь, тухайн сараар	7
Зураг 2. Тав хүртэлх насны хүүхдийн түлэгдэлтийн түвшин, 10 000 хүүхдэд ногдох түвшин	8
1.3. Эхийн эндэгдэл	8
Зураг 1. Эхийн эндэгдэл, 100 000 амьд төрөлтөд ногдох түвшин.....	8
1.4 Перинаталь эндэгдэл	8
Хүснэгт 6. Перинаталь эндэгдэл, 1 000 нийт төрөлтөд ногдох түвшин	9
1.5. Нялхсын эндэгдэл.....	9
Зураг 4. Нялхсын эндэгдэл, 1 000 амьд төрөлтөнд ногдох түвшин	10
Хүснэгт 7. 1 000 амьд төрөлтөнд ногдох нялхсын эндэгдлийн түвшин, шалтгаанаар	10
1.5 Хүүхдийн эндэгдэл	11
Хүснэгт 8. Тав хүртэлх насны хүүхдийн эндэгдэл, 1000 амьд төрөлтөд ногдох түвшин.....	11
Зураг 5. Хүүхдийн эндэгдэл, 1000 амьд төрөлтөд ногдох түвшин	12
Хүснэгт 9. Тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн шалтгаан	12
Зураг 6. 0-14 насны хүүхдийн зам тээврийн ослын шалтгаант нас баралт, тухайн насны 10 000 хүүхдэд ногдох түвшин	12
2.Эмнэлгийн тусламж үйлчилгээ.....	12
2.1. Амбулаторийн тусламж үйлчилгээ.....	12
Зураг 7. Үзлэгийн төрөл, улс, аймгийн дундаж	13
Зураг 8. Нийт үзлэгийн тоо.....	13
Хүснэгт 10. Үзлэгийн төрөл, эзлэх хувиар	14
2. 1. Халдварт бус өвчний эрт илрүүлэг үзлэгийн мэдээлэл	15
Хүснэгт 11. АГ, ЧШ, Элэгний хорт хавдрын эрт илрүүлгийн үзлэгийн хамрагдалтын хувь.....	15
2. 2. Хөх, умайн хүзүүний хорт хавдрын эрт илрүүлэг үзлэгийн мэдээлэл.....	15
Хүснэгт.12. Хөх, умайн хүзүүний хорт хавдрын эрт илрүүлгийн үзлэгийн хамрагдалтын хувь	16

Эрүүл мэндийн сар тутмын мэдээлэл 2026 оны 5 дугаар сар

2.4. Жирэмсний хяналт	16
Хүснэгт 13. Жирэмсэн эхийн хяналт	17
Хүснэгт 14. Шинээр хяналтад хамрагдсан жирэмсэн эмэгтэйчүүдийн БЗДХ-ын шинжилгээний үзүүлэлт	18
2.2.Халдварт бус өвчлөл	19
Хүснэгт 15. Халдварт бус өвчлөлийн зарим үзүүлэлтүүд (осол гэмтэл, хорт хавдар).....	19
Зураг 9. Халдварт бус өвчин, өвчлөлийн төрлөөр	20
Зураг 10. Халдварт бус өвчний төрөл, хүйсээр, 10 000 хүн амд ногдох түвшин	20
2.5. Үр хөндөлт.....	21
Зураг 11. Үр хөндөлтийн эзлэх хувь , эмнэлгийн төрлөөр	21
Зураг 12. Үр хөндөлтийн мэдээ, харьяаллаар	21
2.6. Түргэн тусламжийн дуудлага.....	21
Хүснэгт 16. Түргэн тусламжийн дуудлага, төрлөөр.....	22
2.7. Хэвтэн эмчлүүлэгсдийн тусламж үйлчилгээ	22
Хүснэгт 17. Стационарын тусламж үйлчилгээний зарим үзүүлэлтүүд.....	23
3. Хүн амын нас баралт	23
Зураг 13. Хүн амын нас баралтын тоо, эмнэлгийн нас баралтын эзлэх хувь	24
Зураг 14. Харьяаллын нас баралт, 1 000 хүн амд ногдох түвшин	24
Зураг 15. Сэргийлж болох нас баралтын нийт нас баралтад эзлэх хувь, харьяаллаар.....	25
Зураг 16. Нас баралтын шалтгаан, 10 000 хүн амд ногдох түвшин, 2025-2026 он	25
Зураг 17. Зүрх судасны эрхтэн тогтолцооны шалтгаант нас баралт, харьяаллаар, 10 000 хүн амд ногдох түвшин	26
Зураг 18. Хорт хавдрын шалтгаант нас баралт, харьяаллаар 10000 хүн амд ногдох түвшин.....	26
Зураг 19. Чихрийн шижин өвчний шалтгаант нас баралт, 10000 хүн амд ногдох түвшин	27
Зураг 20. Амьсгалын замын архаг өвчний шалтгаант нас баралт, 10000 хүн амд ногдох түвшин	27
Хүснэгт 18. Осол гэмтэл, гадны шалтгаант нас баралтын үзүүлэлт.....	28
Зураг 21. Амиа хорлож нас барсан тохиолдлын 10 000 хүн амд ногдох түвшин.....	29
Зураг 22. Санамсаргүй хордох, хорт бодист өртснөөс шалтгаалсан нас барсан тохиолдлын түвшин, 10000 хүн амд ногдох түвшин	29
4. Халдварт өвчин.....	30
Зураг 23. Нийт халдварт өвчин, 10000 хүн амд ногдох түвшин	30
Халдварт өвчний нас баралт.....	30
4.1. Амьсгалын замын халдварт өвчин	30
Зураг 24. Амьсгалын замын халдварт өвчин, тохиолдлын тоогоор	30
Хүснэгт 19. Амьсгалын замын халдварт өвчин, 10 000 хүн амд ногдох түвшин	31

Эрүүл мэндийн сар тутмын мэдээлэл 2026 оны 5 дугаар сар

4.2. Бэлгийн замаар дамжих халдварт өвчин	31
Зураг 25. Бэлгийн замын халдварт өвчин, тохиолдлын тоогоор	31
Хүснэгт 20. Бэлгийн замын халдварт өвчин, 10 000 хүн амд ногдох түвшин	32
4.3 Цусан халдвар.....	32
Зураг 26. Вируст гепатитын халдвар, тохиолдлын тоогоор	33
Хүснэгт 21. Вируст гепатитын халдварт өвчин, 10 000 хүн амд ногдох түвшин	33
4.4. Гэдэсний халдвар	34
Зураг 27. Гэдэсний халдварт өвчин, тохиолдлын тоогоор	34
Хүснэгт 22. Гэдэсний халдварууд, 10 000 хүн амд ногдох түвшин	34
Зоонозын болон амьтнаас хүнд халдварладаг өвчлөл	35
Зураг 28. Зоонозын халдварт өвчин, тохиолдлын тоогоор	35
Хүснэгт 23. Зоонозын болон амьтнаас хүнд халдварладаг өвчлөл, 10 000 хүн амд ногдох түвшин.....	35

ЭРҮҮЛ МЭНДИЙН СТАТИСТИК ҮЗҮҮЛЭЛТҮҮД

№	Үзүүлэлт			Нэгж	Өвөрхангай аймаг			Улсын дундаж		
					2025 он	2026 он	Өсөлт бууралт	2025 он	2026 он	Өсөлт бууралт
1	Төрсөн эх			Бодит тоо	679	566	-113.0	22375	21466	-909
2	Амьд төрсөн хүүхэд			Бодит тоо	689	570	-119.0	22556	21679	-877
3	Амьгүй төрсөн хүүхэд			Бодит тоо	0	3	3.0	104	78	-26
				1000 нийт төрөлтөд	0.0	5.2	5.2	4.6	3.6	-1.0
4	Эхийн эндэгдэл			Бодит тоо	0	0	0.0	9	4	-5
				100 000 амьд төрөлтөд	0.0	0.0	0.0	39.9	18.5	-21.4
5	5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл /0-4 нас 364 хоног/			Бодит тоо	15	5	-10.0	377	330	-47
				1000 амьд төрөлтөд	21.8	8.8	-13.0	16.7	15.2	-1.5
6	Үүнээс:	Нялхсын эндэгдэл /0-364 хоног/	Бодит тоо	13	2	-11.0	320	277	-43	
			1000 амьд төрөлтөд	18.9	3.5	-15.4	14.2	12.8	-1.4	
		Нярайн эндэгдэл /0-28 хоног/	Бодит тоо	9	1	-8.0	209	151	-58	
			1000 амьд төрөлтөд	13.1	1.8	-11.3	9.3	7.0	-2.3	
			Нялхсын эндэгдэлд эзлэх хувь	69.2	50.0	-19.2	65.3	54.5	-10.8	
		Нярайн эрт үеийн эндэгдэл /0-6 хоног/	Бодит тоо	9	1	-8.0	156	99	-57	
			Нярайн эндэгдэлд эзлэх хувь	100.0	100.0	0.0	74.6	65.6	-9.0	
			Нярайн хожуу үеийн эндэгдэл /7-28 хоног/	Бодит тоо	0	0	0.0	53	52	-1
		Нярайн эндэгдэлд эзлэх хувь		0.0	0.0	0.0	25.4	34.4	9.0	
		7	Перинаталь эндэгдэл			Бодит тоо	9	4	-5.0	260
1000 нийт төрөлтөд	13.1					7.0	-6.1	11.5	8.1	-3.4
8	Нийт нас баралт			Бодит тоо	229	250	21.0	7219	7308	89
9	Эмнэлгийн нас баралт			Бодит тоо	35	59	24.0	2462	2490	28
				Хувь	15.3	23.6	8.3	34.1	34.1	0.0
10	Эмнэлэгт хоног болоогүй нас баралт			Бодит тоо	14	26	12.0	521	511	-10
				Хувь	40.0	44.1	4.1	21.2	20.5	-0.7
11	Жирэмсний эрт хяналт			Хувь	95.5	94.7	-0.8	93.7	93.4	-0.3
12	Эмчлэгдсэн хүний тоо			Бодит тоо	12977	11445	-1532	424842	376918	-47924
13	Ор хоног			Бодит тоо	89321	76611	-12710	2835111	2491232	-343879
14	Халдварт өвчин			Бодит тоо	426	617	191.0	22597	20722	-1875
				10 000 хүн амд	37.0	53.9	17.0	63.7	60.5	-3.2
15	Амьсгалын замын халдварт өвчин			Бодит тоо	279	513	234.0	13227	7921	-5306
				10 000 хүн амд	24.2	44.9	20.6	37.3	23.1	-14.2
16	Бэлгийн замаар дамжих халдварт өвчин			Бодит тоо	111	75	-36.0	4658	3793	-865
				10 000 хүн амд	9.6	6.6	-3.1	13.1	11.1	-2.0
17	Гэдэсний халдварт өвчин			Бодит тоо	16	4	-12.0	2272	5944	3672
				10 000 хүн амд	1.4	0.3	-1.0	6.4	17.4	11.0
18	Зоонозын халдварт өвчин			Бодит тоо	2	10	8.0	48	126	78
				10 000 хүн амд	0.2	0.9	0.7	0.1	0.4	0.3
19	Цусаар дамжих халдварт өвчин			Бодит тоо	2	2	0.0	89	73	-16
				10 000 хүн амд	0.2	0.2	0.0	0.3	0.2	-0.1
20	Бусад халдварт өвчин			Бодит тоо	16	13	-3.0	2303	2865	562
				10 000 хүн амд	1.4	1.1	-0.3	6.5	8.4	1.9

ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ,ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАРЫН ҮЗҮҮЛЭЛТ

д/д	Үзүүлэлт	Аймгийн хүрэх түвшин (2026 он)	Хүрсэн түвшин (2026 оны 05 сар)
1	Артерийн даралт ихсэх өвчний эрт илрүүлгэнд хамрагдсан 18 ба түүнээс дээш насны хүн амын эзлэх хувь	66.6	28.3
2	Чихрийн шижин хэв шинж-2 өвчний эрт илрүүлгэнд хамрагдсан 35 ба түүнээс дээш насны хүн амын эзлэх хувь	79.1	35.1
3	Хөхний өмөнгийн эрт илрүүлгийн үзлэгт хамрагдсан 30 ба түүнээс дээш насны эмэгтэйчүүдийн тоо	18930	9275
4	Умайн хүзүүний өмөнгийн эрт илрүүлгэнд хамрагдсан 30 ба түүнээс дээш насны эмэгтэйчүүдийн эзлэх хувь	62.6	28.0
5	Урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэг үзлэг, шинжилгээ, оношилгоонд хамрагдалтын хувь	27.6	25.2
6	В вирүст гепатитийн эсрэг сэргийлэх тарилгын 24 цагийн хамралтын хувь	100	98.3
7	Тавт (сахуу, хөхүүл ханиад, татран, В гепатит, хемофилюсинфлюенза) сэргийлэх тарилгын хамралтын хувь	93.4	87.3
8	Улаанбурхан-гахайн хавдар-улаануудын (УГУ) эсрэг сэргийлэх тарилгын хамралтын хувь /2-р тун/	96.7	77.1
9	Эхийн эндэгдлийн түвшин (100 000 амьд төрөлт тутамд)	0.0	0
10	Нялхсын эндэгдлийн түвшин (1000 амьд төрөлт тутамд)	16.9	3.5
11	Нярайн эндэгдлийн түвшин (1000 амьд төрөлт тутамд)	12.1	1.8
12	5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин(1000 амьд төрөлт тутамд)	21.3	8.8
13	Амьгүй төрөлтийн түвшин (1000 төрөлт тутамд)	1.2	5.2
14	Жирэмсний эхний 3 сард хяналтад орсон эхийн эзлэх хувь	97.8	94.7
15	Өсвөр насны 1000 эмэгтэйд ногдох төрөлтийн түвшин	6.2	2.0
16	Сүрьеэгийн өвчлөлийн түвшин, (10 000 хүн амд)	3.4	1.7
17	Вирүст гепатитын өвчлөлийн түвшин, (10 000 хүн амд)	0.3	0.2
18	Зүрх судасны өвчлөлөөс шалтгаалсан нас баралтын түвшин, (10 000 хүн амд)	16.8	8.1
19	Хорт хавдраас шалтгаалсан нас баралтын түвшин, (10 000 хүн амд)	10.2	5.2
20	Амиа хорлож нас барсан тохиолдлын түвшин, (10 000 хүн амд)	2.2	1.2
21	Санамсаргүй хордох, хорт бодист өртсөнөөс шалтгаалсан нас баралтын түвшин, (10 000 хүн амд)/Х40-49/	1.2	1.4
22	0-5 насны хүүхдийн түлэгдэлтийн түвшин (10 000 хүүхдэд, Т20-Т32)	54.3	23.8
23	Хүүхдийн зам тээврийн ослын шалтгаант нас баралтын түвшин (10 000 хүүхдэд, V00-V99)	1.6	0.6
Нэмэлт үзүүлэлт			
24	Чихрийн шижингийн шалтгаант нас баралтын түвшин, 10000 хүнд	0.3	0.3
25	Амьсгалын замын архаг өвчний шалтгаант нас баралтын түвшин, 10000 хүнд	2.2	0.4
26	Сэргийлэх боломжтой нас баралтын нийт нас баралтад эзлэх хувь (0-74нас)	58	49.6
27	Халдварт өвчний тохиолдлын тоо, 10000 хүн амд	79.6	54.5
28	Бүх хэлбэрийн сүрьеэгийн эмчилгээний амжилтын хувь	95.7	92
29	Үр хөндөлтийн харьцаа, 1000 амьд төрөлтөд ногдох	72.8	117.5
30	Жирэмсний хугацаанд 6 ба түүнээс дээш удаа хяналтад хамрагдсан эмэгтэйчүүдийн эзлэх хувь	79.0	73.7

1. Эх, хүүхдийн эрүүл мэнд

Төрөлт

Аймгийн хэмжээнд 2026 оны эхний 5 сарын байдлаар 566 эх төрсөн нь өнгөрсөн оны мөн үеэс 113 төрөлтөөр буюу 16.6 хувиар буурсан байна. Төрсөн эхчүүдийн 417 нь буюу 73.7 хувь нь эмчийн хяналтын үзлэгт 6 ба түүнээс дээш удаа хамрагдаж улсын дунджаас 12.4 хувиар доогуур үзүүлэлттэй байна. 2026 оны эхний 5 сарын байдлаар мэс заслын аргаар төрсөн эхчүүдийн тоо 190 болж, нийт төрөлтийн 33.6 хувийг эзэлж байна.


Төрсөн эхчүүдийн 85.2 хувь нь Бүсийн оношилгоо эмчилгээний төвд, 11.0 хувь нь Хархорин сумын нэгдсэн эмнэлэгт, 3.7 хувь нь сумын эрүүл мэндийн төвд, 0.2 хувь нь гэртээ төрсөн байна.

Хүснэгт 1. Төрөлт, төрөх үед үзүүлсэн эмнэлгийн тусламж, хувиар

№	Нэгжийн нэр	Амьд төрсөн хүүхдийн тоо (харьяаллаар)	Төрсөн эхийн тоо (харьяаллаар)	Төрөлтийн эзлэх хувь, харьяаллаар					Өсвөр насны охидын төрөлтийн тоо (харьяаллаар)	Өсвөр насны 1000 эмэгтэйд ногдох төрөлтийн түвшин (10-19 нас)	Жирэмсний хяналтанд 6 ба түүнээс дээш удаа хамрагдаж төрсөн эхийн эзлэх хувь (харьяаллаар)
				Бүсийн оношилгоо эмчилгээний төв (аймаг, хотын нэгдсэн эмнэлэг)	Сумын нэгдсэн эмнэлэг (ХХНЭмнэлэг)	Сумын эрүүл мэндийн төв	Хувийн эмнэлэг	Гэртээ			
А	Б	1	2	3	4	5	6	7	8	9	10
1	Баруунбаян-Улаан	16	16	93.8	0.0	6.3	0.0	0.0	1	4.7	56.3
2	Бат-Өлзий	32	32	93.8	3.1	3.1	0.0	0.0	2	2.6	75.0
3	Баянгол	17	17						2	6.6	88.2
4	Баян-Өндөр	5	5	100.0	0.0	0.0	0.0	0.0		0.0	60.0
5	Богд	29	29	89.7	0.0	10.3	0.0	0.0	1	2.1	82.8
6	Бүрд	2	2	50.0	50.0	0.0	0.0	0.0		0.0	100.0
7	Гучин-Ус	12	12	91.7	0.0	8.3	0.0	0.0		0.0	100.0
8	Есөнзүйл	7	8	87.5	0.0	12.5	0.0	0.0		0.0	75.0
9	Зүүнбаян-улаан	18	18	100.0	0.0	0.0	0.0	0.0		0.0	61.1
10	Нарийнтгээл	8	8	100.0	0.0	0.0	0.0	0.0		0.0	50.0
11	Өлзийт	5	5							0.0	20.0
12	Сант	14	14	92.9	7.1	0.0	0.0	0.0		0.0	71.4
13	Тарагт	13	11	100.0	0.0	0.0	0.0	0.0		0.0	45.5
14	Төгрөг	14	14	92.9	0.0	7.1	0.0	0.0	1	4.6	64.3
15	Уянга	46	45	95.6	0.0	4.4	0.0	0.0	4	4.8	68.9
16	Хайрхандулаан	11	11	81.8	0.0	18.2	0.0	0.0	1	3.9	72.7
17	Хархорин		0								
18	Хужирт	22	21	81.0	0.0	19.0	0.0	0.0		0.0	85.7
19	Уянсэтгэл ӨЭМТ	49	50	100.0	0.0	0.0	0.0	0.0	1	1.0	74.0
20	Түшигдөлгөөн ӨЭМТ	55	54	100.0	0.0	0.0	0.0	0.0	1	1.0	79.6
21	Нарны дөш ӨЭМТ	77	76	98.7	0.0	0.0	0.0	1.3	2	1.2	64.5
22	Энэрэл-Хархорин ӨЭМТ	47	47	12.8	87.2	0.0	0.0	0.0		0.0	95.7
23	Харьяалалын бус	71	71	67.6	25.4	7.0	0.0	0.0	5		73.2
24	Өвөрхангай аймаг	570	566	85.2	11.0	3.7	0.0	0.2	21	2.0	73.7
25	Улсын дундаж			92.2	3.2	2.3	2.1	0.3			86.1

Эрүүл мэндийн сар тутмын мэдээлэл 2026 оны 5 дугаар сар

Зураг 1. Амьд төрсөн хүүхдийн тоо



2026 оны эхний 5 сард 570 амьд хүүхэд төрж, өмнөх оны мөн үеэс 119 тохиолдлоор, сүүлийн 10 жилийн дундажтай харьцуулахад 266 тохиолдлоор тус тус буурсан үзүүлэлттэй байна.

1.2. Хүүхдийн эрүүл мэнд

2026 оны эхний 5 сарын байдлаар 566 эх төрж, 570 амьд хүүхэд мэндэлж, 3 амьгүй төрөлт бүртгэгдэж, төрөлтийн түвшин 1000 хүн амд 5.0 байна. Амьд төрсөн хүүхдийн 263 буюу 46.1 хувь нь хүү, 307 буюу 53.9 хувь нь охин байна. Амьд төрсөн нийт хүүхдээс 23 нярай буюу 4.0 хувь нь 2500 грамаас доош жинтэй, төрөлхийн хөгжлийн гажигтөй төрсөн 1 тохиолдол бүртгэгдсэн байна. Төрсний дараа 1 цагийн дотор хөхөө амласан хүүхэд 96.0 хувийг эзэлж байна.

Хүснэгт 2. Амьд төрсөн хүүхэд, эхийн тээлтийн хугацаа, хувиар

№	Төрсөн газар/эмнэлэг	Амьд төрсөн хүүхдийн тоо (төрсөн газраар)	Эхийн тээлтийн хугацаа, эзлэх хувь					Төрөлхийн гажигтай төрсөн хүүхдийн эзлэх хувь	2500 граммаас доош жинтэй төрсөн хүүхдийн эзлэх хувь
			22-28 долоо хоногтой	29-32 долоо хоногтой	33-36 долоо хоногтой	37-41 долоо хоногтой	42 долоо хоногоос дээш		
А	Б	1	2	3	4	5	6	7	8
1	Баруунбаян-Улаан	0							
2	Бат-Өлзий	3	0.0	0.0	0.0	100.0	0.0	0.0	0.0
3	Баянгол	0							
4	Баян-Өндөр	0							
5	Богд	3	0.0	0.0	0.0	100.0	0.0	0.0	0.0
6	Бүрд	1	0.0	0.0	0.0	100.0	0.0	0.0	0.0
7	Гучин-Ус	1	0.0	0.0	0.0	100.0	0.0	0.0	0.0
8	Есөнзүйл	0							
9	Зүүнбаян-улаан	0							
10	Нарийнтээл	2	0.0	0.0	100.0	0.0	0.0	0.0	0.0
11	Өлзийт	0							
12	Сант	0							
13	Тарагт	0							
14	Төгрөг	1	0.0	100.0	0.0	0.0	0.0	0.0	100.0
15	Уянга	2	0.0	0.0	0.0	100.0	0.0	0.0	0.0
16	Хайрхандулаан	2	0.0	0.0	0.0	100.0	0.0	0.0	0.0
17	Хархорин НЭ	62	0.0	0.0	3.2	96.8	0.0	0.0	1.6
18	Хужирт	6	0.0	0.0	0.0	100.0	0.0	0.0	0.0
19	БОЭТ	487	0.0	0.2	5.3	94.3	0.2	0.2	4.3
20	Уянсэтгэл ӨЭМТ	0							
21	Түшигдөлгөөн	0							
22	Нарны дөш ӨЭМТ	0							
23	Энэрэл-Хархорин	0							
24	Өвөрхангай аймаг	570	0.0	0.4	5.3	94.2	0.2	0.2	4.0
25	Улсын дундаж		0.3	0.9	5.3	93.3	0.1	1.0	4.7

Эрүүл мэндийн сар тутмын мэдээлэл 2026 оны 5 дугаар сар

2026 оны эхний 5 сард 0-5 хүртэлх насны хүүхдийн өсөлт хөгжлийн хяналтад 13630 хүүхэд хамрагдсанаас 0.15 хувь нь туранхай, 0.07 хувь нь тураалтай, 0.08 хувь нь өсөлтийн хоцрогдолтой байна.

Хүснэгт 3. Тав хүртэлх насны хүүхдийн жингийн мэдээ, хувиар

№	Нэгжийн нэр	Жинлэсэн хүүхдийн тоо	Жингийн мэдээ (эзлэх хувиар)			А амин дэм уусан	Д амин дэм уусан	Олон найрлагат бичил тэжээл хэрэглэсэн хүүхдийн тоо
			Туранхай /жин, өндөр/	Тураалтай /жин насны үзүүлэлт/	Өсөлтийн хоцрогдолтой /өндөр насны үзүүлэлт/			
А	Б	1	2	3	4	5	6	7
1	Баруунбаян-Улаан	94	0.00	0.00	0.00	48	101	0
2	Бат-Өлзий	1629	0.55	0.00	0.43	333	270	30
3	Баянгол	638	0.00	0.00	0.00	176	437	0
4	Баян-Өндөр	258	0.00	0.00	0.00	88	215	0
5	Богд	224	0.00	0.45	0.00	220	167	33
6	Бүрд	313	0.32	0.64	0.32	150	230	0
7	Гучин-Ус	184	0.00	0.00	0.00	59	137	2
8	Есөнзүйл	713	0.00	0.00	0.00	81	369	15
9	Зүүнбаян-улаан	313	0.32	0.00	0.32	107	220	0
10	Нарийнтээл	161	0.00	0.00	0.00	51	117	0
11	Өлзийт	195	0.00	0.00	0.00	12	0	22
12	Сант	647	0.77	0.15	0.00	110	416	0
13	Тарагт	292	0.00	0.00	0.00	261	169	6
14	Төгрөг	279	0.00	0.00	0.00	150	327	0
15	Уянга	2824	0.00	0.00	0.00	54	339	6
16	Хайрхандулаан	409	0.00	0.00	0.00	0	282	68
17	Хархорин	0				0	0	0
18	Хужирт	145	0.69	0.69	0.69	8	105	0
19	БОЭТ	0				0	0	0
20	Уянсэгтэл ӨЭМТ	618	0.32	0.00	0.16	601	587	5
21	Түшигдөлгөөн ӨЭМТ	1549	0.06	0.06	0.00	532	1205	86
22	Нарны дөш ӨЭМТ	744	0.00	0.40	0.00	1399	1163	1
23	Энэрэл-ХХ ӨЭМТ	1401	0.07	0.07	0.00	895	1061	0
24	Өвөрхангай	13630	0.15	0.07	0.08	5335	7917	274
25	Улсын дундаж		0.13	0.10	0.13			

Эрүүл мэндийн сар тутмын мэдээлэл 2026 оны 5 дугаар сар

Заавал хийх дархлаажуулалтын хамрагдалтын мэдээ

Хүснэгт 4. Дархлаажуулалтын хамрагдалтын хувь, тухайн сараар

№	Нэгжийн нэр	Халдварт сүрьеэгийн эсрэг вакцин (БЦЖ)			В вирус гепатитын эсрэг сэргийлэх тарилгын 24 цагийн хамрагдалтын хувь			Халдварт саа 1-р тун			Халдварт саа 3-р тун			ХПВ-ын эсрэг вакцин		
		Хамрагдвал зохих	Хамрагдсан	Хувь	Хамрагдах	Хамрагдсан	Хувь	Хамрагдвал зохих	Хамрагдсан	Хувь	Хамрагдвал зохих	Хамрагдсан	Хувь	Хамрагдвал зохих	Хамрагдсан	Хувь
А	Б	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	15
1	Баруунбаян-Улаан							2	2	100.0	2	2	100.0			
2	Бат-Өлзий	1	1	100.0	1	1	100.0	8	8	100.0	13	11	84.6	177	160	90.4
3	Баянгол							2	2	100.0	1	1	100.0			
4	Баян-Өндөр							4	4	100.0	1	1	100.0	56	45	80.4
5	Богд	1	1	100.0	1	1	100.0	11	11	100.0	10	7	70.0	85	75	88.2
6	Бүрд	1	1	100.0	1	1	100.0				3	3	100.0	28	28	100.0
7	Гучин-Ус							3	3	100.0	2	2	100.0	28	15	53.6
8	Есөнзүйл							1	1	100.0	2	2	100.0			
9	Зүүнбаян-улаан							3	3	100.0	3	3	100.0	34	29	85.3
10	Нарийнтгээл							1	1	100.0	2	2	100.0	51	51	100.0
11	Өлзийт							1	1	100.0	1	1	100.0	15	13	86.7
12	Сант							2	1	50.0				54	47	87.0
13	Тарагт							2		0.0	1	1	100.0			#DIV/0!
14	Төгрөг							2	1	50.0	2	2	100.0	44	34	77.3
15	Уянга							11	10	90.9	9	8	88.9			
16	Хайрхандулаан							3	3	100.0	5	4	80.0			
17	Хархорин	8	8	100.0	8	8	100.0									
18	Хужирт	1	1	100.0	1	1	100.0	4	2	50.0	6	6	100.0	126	57	45.2
19	Нарны дөш	24	24	100.0	24	24	100.0	31	31	100.0	21	18	85.7	404	145	35.9
20	Уянсэтгэл	13	13	100.0	13	13	100.0	16	15	93.8	16	16	100.0	240	168	70.0
21	Түшиг-дөлгөөн	19	19	100.0	21	19	90.5	18	18	100.0	10	10	100.0	323	229	70.9
22	Энэрэл Хархорин							14	14	100.0	16	10	62.5			
23	БОЭТ	45	45	100.0	45	45	100.0									
24	Өвөрхангай аймаг	113	113	100.0	115	113	98.3	139	131	94.2	126	110	87.3	1665	1096	65.8

Эрүүл мэндийн сар тутмын мэдээлэл 2026 оны 5 дугаар сар


Хүснэгт 5. Дархлаажуулалтын хамрагдалтын хувь, тухайн сараар

№	Нэгжийн нэр	Тавт /СХТ + Геп В +ХиВ-ийн 3-р тун/			Улаанбурхан, Гахайн хавдар, Улаануудын эсрэг вакцин 2-р тун			А гепатит 1-р тун			Пневмококкийн эсрэг сэргийлэх тарилга 1-р тун			Пневмококкийн эсрэг сэргийлэх тарилга 3-р тун		
		Хамрагдвал зохиx	Хамрагдсан	Хувь	Хамрагдвал зохиx	Хамрагдсан	Хувь	Хамрагдвал зохиx	Хамрагдсан	Хувь	Хамрагдвал зохиx	Хамрагдсан	Хувь	Хамрагдвал зохиx	Хамрагдсан	Хувь
А	Б	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	15
1	Баруунбаян-Улаан	2	2	100.0	4	3	75.0	3	1	33.3	2	2	100.0	1	1	100.0
2	Бат-Өлзий	13	11	84.6	6	6	100.0	11	10	90.9	8	8	100.0	5	4	80.0
3	Баянгол	1	1	100.0	4	3	75.0	3		0.0	2	2	100.0	2	2	100.0
4	Баян-Өндөр	1	1	100.0	5	3	60.0	6	5	83.3	4	4	100.0	3	3	100.0
5	Богд	10	7	70.0	12	11	91.7	8	8	100.0	11	11	100.0	5	3	60.0
6	Бүрд	3	3	100.0	4	3	75.0	2	2	100.0			#####	2	2	100.0
7	Гучин-Ус	2	2	100.0	2	2	100.0	2	2	100.0	3	3	100.0	2	2	100.0
8	Есөнзүйл	2	2	100.0	2	2	100.0	1	1	100.0	1	1	100.0	2	2	100.0
9	Зүүнбаян-улаан	3	3	100.0	4	4	100.0	5	5	100.0	3	3	100.0	2	2	100.0
10	Нарийнтгээл	2	2	100.0	2	2	100.0	3	2	66.7	1	1	100.0	1	1	100.0
11	Өлзийт	1	1	100.0				2	2	100.0	1	1	100.0	1	1	100.0
12	Сант				4	3	75.0				2	1	50.0	1	1	100.0
13	Тарагт	1	1	100.0				2	1	50.0	2		0.0	4	4	100.0
14	Төгрөг	2	2	100.0							2	1	50.0	2	2	100.0
15	Уянга	9	8	88.9	14	6	42.9	14	6	42.9	11	10	90.9	9	4	44.4
16	Хайрхан-дулаан	5	4	80.0	4	4	100.0				3	3	100.0	4	4	100.0
17	Хархорин															
18	Хужирт	6	6	100.0	5	2	40.0	7	4	57.1	4	2	50.0	9	3	33.3
19	Нарны дөш	21	18	85.7	21	17	81.0	25	20	80.0	31	31	100.0	27	23	85.2
20	Уянсэтгэл	16	16	100.0	17	16	94.1	15	15	100.0	16	15	93.8	13	11	84.6
21	Түшиг-дөлгөөн	10	10	100.0	13	11	84.6	11	11	100.0	18	18	100.0	7	7	100.0
22	Энэрэл Хархорин	16	10	62.5	21	13	61.9	21	14	66.7	14	14	100.0	11	6	54.5
23	БОЭТ															
24	Өвөрхангай аймаг	126	110	87.3	144	111	77.1	141	109	77.3	139	131	94.2	113	88	77.9

2026 оны эхний 5 сарын байдлаар 5 хүртэлх насны хүүхдийн түлэгдэлтийн 25 тохиолдол бүртгэгдэж тухайн насны 10 000 хүүхдэд 23.8 ногдож байгаа ба өвчлөлийн тохиолдол 25, нас баралтын тохиолдол бүртгэгдээгүй байна.

Эрүүл мэндийн сар тутмын мэдээлэл 2026 оны 5 дугаар сар


Зураг 2. Тав хүртэлх насны хүүхдийн түлэгдэлтийн түвшин, 10 000 хүүхдэд ногдох түвшин



1.3. Эхийн эндэгдэл

Аймгийн хэмжээнд 2026 оны эхний 5 сарын байдлаар эхийн эндэгдлийн тохиолдол бүртгэгдээгүй байна. Сүүлийн 5 жилийн дунджаар 100 000 амьд төрөлтөд ногдох эхийн эндэгдлийн түвшин 0.0 байна.

Зураг 1. Эхийн эндэгдэл, 100 000 амьд төрөлтөд ногдох түвшин



1.4 Перинаталь эндэгдэл

Аймгийн хэмжээнд 2026 оны эхний 5 сарын байдлаар перинаталь эндэгдлийн 4 тохиолдол бүртгэгдэж, 1000 нийт төрөлтөд 7.0 ногдож байна. Улсын дундажтай харьцуулахад 1.1 пунктээр доогуур үзүүлэлттэй байна. 0-6 хоногтой эрт үеийн нярайн эндэгдлийн 1 тохиолдол бүртгэгдэж перинаталь эндэгдлийн 25.0 хувийг, амьгүй төрөлтийн 3 тохиолдол бүртгэгдэж 75.0 хувийг тус тус эзэлж байна.

Эрүүл мэндийн сар тутмын мэдээлэл 2026 оны 5 дугаар сар

Хүснэгт 6. Перинаталь эндэгдэл, 1 000 нийт төрөлтөд ногдох түвшин


№	Нэгжийн нэр	Амьгүй төрөлт				0-6 хоногтой эрт үеийн нярайн эндэгдэл				Перинаталь эндэгдэл	
		БОЭТ	Сум, гэртээ	Бүгд	1000 нийт төрөлтөд	БОЭТ	Сум, гэртээ	Бүгд	1000 нийт төрөлтөд	Тохиолдлын тоо	1000 нийт төрөлтөд
А	Б	1	2	3	4	5	6	7	8	9	10
1	БаруунБаян-Улаан	1		1	58.8			0	0.0	1	58.8
2	Бат-Өлзий			0	0.0			0	0.0	0	0.0
3	Баянгол			0				0		0	0.0
4	Баян-Өндөр			0	0.0			0	0.0	0	0.0
5	Богд			0	0.0			0	0.0	0	0.0
6	Бүрд			0	0.0			0	0.0	0	0.0
7	Гучин-Ус			0	0.0			0	0.0	0	0.0
8	Есөнзүйл		1	1	125.0			0	0.0	1	125.0
9	Зүүнбаян-улаан			0	0.0			0	0.0	0	0.0
10	Нарийнтээл			0	0.0			0	0.0	0	0.0
11	Өлзийт			0	0.0			0	0.0	0	0.0
12	Сант			0	0.0			0	0.0	0	0.0
13	Тарагт			0	0.0			0	0.0	0	0.0
14	Төгрөг			0	0.0		1	1	71.4	1	71.4
15	Уянга			0	0.0			0	0.0	0	0.0
16	Хайрхандулаан			0	0.0			0	0.0	0	0.0
17	Хархорин НЭ							0		0	
18	Хужирт			0	0.0			0	0.0	0	0.0
19	Уянсэтгэл ӨЭМТ	1		1	20.0			0	0.0	1	20.0
20	Түшигдөлгөөн ӨЭМТ			0	0.0			0	0.0	0	0.0
21	Нарны дөш ӨЭМТ			0	0.0			0	0.0	0	0.0
22	Энэрэл-ХХ ӨЭМТ			0	0.0			0	0.0	0	0.0
23	Харьяалалын бус			0	0.0			0	0.0	0	0.0
24	Өвөрхангай аймаг	2	1	3	5.2	0	1	1	1.8	4	7.0
25	Улсын дундаж				3.6						8.1

1.5. Нялхсын эндэгдэл

Аймгийн хэмжээнд 2026 оны эхний 5 сарын байдлаар нялхсын эндэгдлийн 2 тохиолдол бүртгэгдэж, 1000 амьд төрөлтөд 3.5 ногдож байгаа нь өнгөрсөн оны мөн үеэс 11 тохиолдлоор буюу 15.4 пунктээр, улсын дунджаас 9.3 пунктээр тус тус буурсан үзүүлэлттэй байна.

Эрүүл мэндийн сар тутмын мэдээлэл 2026 оны 5 дугаар сар

Зураг 4. Нялхсын эндэгдэл, 1 000 амьд төрөлтөнд ногдох түвшин



2026 оны эхний 5 сарын байдлаар 1000 амьд төрөлтөд ногдох нялхсын эндэгдлийг сумуудаар харьцуулбал: Төгрөг (71.4), Хужирт (45.5) сумдуудад аймгийн дунджаас 42.0-67.9 пунктээр өндөр үзүүлэлттэй байна.

Нялхсын эндэгдлийг шалтгаанаар авч үзвэл: Перинаталь үед үүссэн эмгэгийн шалтгаант эндэгдэл 50.0 хувийг эзэлж байна.

Хүснэгт 7. 1 000 амьд төрөлтөнд ногдох нялхсын эндэгдлийн түвшин, шалтгаанаар

№	Нэгжийн нэр	Нялхсын эндэгдэл (0-1 хүртэлх нас)				1 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн тэргүүлэх шалтгаан, бодит тоогоор				
		БОЭТ	СЭМТ, ӨЭМТ, гэртээ	Бүгд	1000 амьд төрөлтөд	Амьсгалын эрхтэн тогтолцоо	Осол гэмтэл, гадны шалтгаан	Перинаталь үед үүссэн эмгэг	Төрөлхийн гажиг	Бусад
	Б	1	2	3	4	5	6	7	8	9
1	БаруунБаян-Улаан			0	0.0					
2	Бат-Өлзий			0	0.0					
3	Баянгол			0						
4	Баян-Өндөр			0	0.0					
5	Богд			0	0.0					
6	Бүрд			0	0.0					
7	Гучин-Ус			0	0.0					
8	Есөнзүйл			0	0.0					
9	Зүүнбаян-улаан			0	0.0					
10	Нарийнтээл			0	0.0					
11	Өлзийт			0						
12	Сант			0	0.0					
13	Тарагт			0	0.0					
14	Төгрөг		1	1	71.4			1		
15	Уянга			0	0.0					
16	Хайрхандулаан			0	0.0					
17	Хархорин									
18	Хужирт		1	1	45.5					1
19	Уянсэтгэл ӨЭМТ			0	0.0					
20	Түшигдөлгөөн ӨЭМТ			0	0.0					
21	Нарны дөш Өрх			0	0.0					
22	Энэрэл-XX Өрх			0	0.0					
23	Харъяалалын бус			0	0.0					
24	Өвөрхангай аймаг	0	2	2	3.5	0	0	1	0	1
25	Улсын дундаж				12.8					

1.5 Хүүхдийн эндэгдэл

Аймгийн хэмжээнд 2026 оны эхний 5 сарын байдлаар 0-5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн 5 тохиолдол бүртгэгдэж, 1 000 амьд төрөлтөнд 8.8 ноогдож байгаа ба өмнөх оны мөн үетэй харьцуулахад 10 тохиолдлоор буюу 13.0 пунктээр, улсын дунджаас 6.4 пунктээр тус тус буурсан үзүүлэлттэй байна.

Тав хүртэлх насандаа эндсэн хүүхдийн 2 тохиолдол буюу 40.0 хувь нь эрэгтэй хүүхэд байна. Нийт тохиолдлын 60.0 хувь нь эмнэлэгт нас барсан ба үүнээс хоног болоогүй нас баралт 100.0 хувийг эзэлж байна.

Шалтгаанаар авч үзвэл: Өвчний шалтгаант эндэгдэл 80.0 хувийг эзэлж байна.


Харьяалах сумдүүдаар харьцуулбал: 1000 амьд төрөлтөд ногдох тав хүртэлх насны хүүхдийн эндэгдэл Богд (34.5), Төгрөг (71.4), Хужирт (45.5) сумдуудад аймгийн дунджаас 25.7-43.2 пунктээр өндөр үзүүлэлттэй байна.

Хүснэгт 8. Тав хүртэлх насны хүүхдийн эндэгдэл, 1000 амьд төрөлтөд ногдох түвшин

№	Сум/өрх	5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл				5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн тэргүүлэх шалтгаан, бодит тоогоор				
		БОЭТ-д	СЭМТ, ӨЭМТ, гэртээ	Бүгд	1000 амьд төрөлтөд	Амьсгалын эрхтэн тогтолцоо	Осол гэмтэл, гадны шалтгаан	Перинаталь үед үүссэн эмгэг	Төрөлхийн гажиг	Бусад
А	Б	1	2	3	4	5	6	7	8	9
1	БаруунБаян-Улаан			0	0.0					
2	Бат-Өлзий			0	0.0					
3	Баянгол			0	0.0					
4	Баян-Өндөр			0	0.0					
5	Богд		1	1	34.5	1				
6	Бүрд			0	0.0					
7	Гучин-Ус			0	0.0					
8	Есөнзүйл			0	0.0					
9	Зүүнбаян-Улаан			0	0.0					
10	Нарийнтээл			0	0.0					
11	Өлзийт			0	0.0					
12	Сант			0	0.0					
13	Тарагт			0	0.0					
14	Төгрөг		1	1	71.4			1		
15	Уянга			0	0.0					
16	Хайрхандулаан			0	0.0					
17	Хархорин									
18	Хужирт		1	1	45.5					1
19	Уянсэгтэл ӨЭМТ			0	0.0					
20	Түшигдөлгөөн ӨЭМТ			0	0.0					
21	Нарны дөш ӨЭМТ			0	0.0					
22	Энэрэл-ХХ ӨЭМТ			0	0.0					
23	Харьяалалын бус		2	2	28.2		1			1
24	Өвөрхангай аймаг	0	5	5	8.8	1	1	1	0	2
25	Улсын дундаж				15.2					

Эрүүл мэндийн сар тутмын мэдээлэл 2026 оны 5 дугаар сар

Зураг 5. Хүүхдийн эндэгдэл, 1000 амьд төрөлтөд ногдох түвшин




Хүснэгт 9. Тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн шалтгаан

№	Өвчний нэршил	Тохиолдлын тоо	Эзлэх хувь
1	Хүүхдийн тархины бусад саа	1	20%
2	Пневмони, тодорхойгүй	1	20%
3	Бага жинтэй төрсөн бусад тохиолдол	1	20%
4	Бусад тодорхойгүй шалтгаанаар гэнэт эндэх	1	20%
5	Зам тээврийн осол	1	20%

0-14 насны хүүхдийн нас баралтын нийт 8 тохиолдол бүртгэгдснээс зам тээврийн ослын шалтгаант нас баралтын 2 тохиолдол бүртгэгдэж нас баралтын 25.0 хувийг эзэлж, тухайн насны 10000 хүүхдэд 0.6 ногдож байна.

Зураг 6. 0-14 насны хүүхдийн зам тээврийн ослын шалтгаант нас баралт, тухайн насны 10 000 хүүхдэд ногдох түвшин




2.Эмнэлгийн тусламж үйлчилгээ

2.1. Амбулаторийн тусламж үйлчилгээ


Аймгийн хэмжээнд 2026 оны эхний 5 сарын байдлаар нийт 234944 эмчийн үзлэг хийгдсэнээс 25.2 хувийг урьдчилан сэргийлэх үзлэг, 61.0 хувийг өвчний учир амбулаторт, 7.2 хувийг идэвхитэй хяналтын үзлэг, 6.6 хувийг гэрийн үзлэг тус тус эзэлж байна.

Эрүүл мэндийн сар тутмын мэдээлэл 2026 оны 5 дугаар сар

Зураг 7. Үзлэгийн төрөл, улс, аймгийн дундаж



Зураг 8. Нийт үзлэгийн тоо



Эрүүл мэндийн сар тутмын мэдээлэл 2026 оны 5 дугаар сар

Хүснэгт 10. Үзлэгийн төрөл, эзлэх хувиар

№	Нэгжийн нэр	Нийт үзлэг	Үүнээс				
			Урьдчилан сэргийлэх үзлэгийн хувь	Өвчний учир амбулаторт	Диспансерийн хяналтын хувь	Гэрийн идэвхитэй хяналтын хувь	Гэрийн дуудлагын хувь
А	Б	1	2	3	4	5	6
1	Баруунбаян-Улаан	964	24.1	35.6	10.1	10.2	20.1
2	Бат-Өлзий	4666	28.4	48.0	9.7	7.9	6.0
3	Баянгол	2846	32.1	45.4	8.9	9.2	4.4
4	Баян-Өндөр	2419	31.7	58.5	1.2	8.4	0.2
5	Богд	2485	55.1	33.7	7.6	2.4	1.2
6	Бүрд	1261	16.7	66.1	3.3	9.4	4.6
7	Гучин-Ус	743	41.5	41.2	6.1	9.6	1.7
8	Есөнзүйл	893	17.8	52.5	10.8	5.0	13.9
9	Зүүнбаян-Улаан	2946	42.0	36.7	2.8	12.8	5.8
10	Нарийнтгээл	3105	41.1	26.7	14.5	6.6	11.1
11	Өлзийт	953	41.2	30.5	8.5	6.7	13.0
12	Сант	1279	28.7	31.6	14.3	18.0	7.4
13	Тарагт	2082	38.4	35.4	10.1	13.9	2.2
14	Төгрөг	1302	14.5	44.9	18.1	12.1	10.3
15	Уянга	8419	28.8	53.4	12.2	1.8	3.7
16	Хайрхандулаан	921	2.7	82.1	5.9	0.8	8.6
17	Хархорин НЭ	29496	4.0	94.9	1.2	0.0	0.0
18	Хужирт	5998	18.5	63.9	9.3	2.2	6.2
19	БОЭТ	94335	20.0	72.4	7.6	0.0	0.0
20	Уянсэгтгэл	9783	40.5	20.1	16.6	19.3	3.5
21	Түшигдөлгөөн	11187	48.5	12.9	10.1	27.5	1.0
22	Нарны дөш	16181	47.9	31.2	6.7	10.4	3.8
23	Энэрэл-хархорин	13254	64.0	9.0	8.5	17.5	1.0
24	Чинмэнд	1969					
25	Асар хайрхан	0					
26	Ачтан ирээдүй	997	0.0	100.0	0.0	0.0	0.0
27	Ариунсанаа	611	14.1	85.9	0.0	0.0	0.0
28	Агь манба	704	0.0	100.0	0.0	0.0	0.0
29	Сидармед	798	2.1	97.9	0.0	0.0	0.0
30	Үүдэн эмнэлгүүд	12347	1.5	94.8	3.7	0.0	0.0
31	Өвөрхангай аймаг	234944	25.2	61.0	7.2	5.0	1.6

2. 1. Халдварт бус өвчний эрт илрүүлэг үзлэгийн мэдээлэл

Аймгийн хэмжээнд 2026 оны эхний 5 сарын байдлаар артерийн гипертензи эрт илрүүлэг үзлэгт 18-аас дээш насны нийт 20578 хүн хамрагдсан бөгөөд эрэгтэйчүүдийн үзлэг 41.5 хувийг, эмэгтэйчүүдийн үзлэг 58.8 хувийг тус тус эзэлж байна. Үр дүнгийн үзүүлэлтээр нийт үзлэгийн **0.83** хувь нь артерийн гипертензи онош батлагдсан байна. Чихрийн шижин өвчний эрт илрүүлэг үзлэгт 35-аас дээш насны нийт 16271 хүн хамрагдсан бөгөөд эрэгтэйчүүдийн үзлэг 40.0 хувийг, эмэгтэйчүүдийн үзлэг 60.0 хувийг тус тус эзэлж байна. Үр дүнгийн үзүүлэлтээр нийт үзлэгийн **0.35** хувь нь чихрийн шижин онош батлагдсан байна. Элэгний хорт хавдрын эрт илрүүлэг үзлэгт 6428 хүн хамрагдснаас хорт хавдрын 3 тохиолдол шинээр бүртгэгдсэн байна.

Хүснэгт 11. АГ, ЧШ, Элэгний хорт хавдрын эрт илрүүлгийн үзлэгийн хамрагдалтын хувь

№		Артерийн гипертензи		Чихрийн шижин		Артерийн гипертензи эрт илрүүлгийн үзлэг			Чихрийн шижин хэв шинж 2 эрт илрүүлгийн үзлэг			Элэгний хорт хавдрын эрт илрүүлгийн үзлэг	
		Хамрагдвал зохих хүний тоо /18-с дээш нас/	хамрагдсан хувь	Хамрагдвал зохих хүний тоо /35-с дээш нас/	хамрагдсан хувь	Бүгд	давтан	Онош батлагдсан	Бүгд	давтан	Онош батлагдсан	Бүгд	Онош батлагдсан
А	Б	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12
1	Баруунбаян-Улаан	1535	15.4	937	25.2	236	0	0	236	0	0	236	0
2	Бат-Өлзий	4667	43.9	2926	59.4	2051	57	26	1737	23	3	2116	0
3	Баянгол	2334	56.7	1491	60.3	1324	15	9	899	0	0	111	0
4	Баян-Өндөр	2133	18.8	1449	19.9	401	15	0	289	1	1	195	0
5	Богд	3238	17.8	1874	18.5	576	23	9	346	3	3	286	0
6	Бүрд	1735	16.5	1121	19.2	287	8	0	215	6	1	101	0
7	Гучин-Ус	1333	20.0	815	33.6	267	8	1	274	6	0	45	1
8	Есөнзүйл	1671	23.0	1054	15.0	384	24	2	158	6	3	118	0
9	Зүүнбаян-Улаан	2420	26.1	1601	15.5	632	0	0	248	0	0	37	0
10	Нарийнтээл	2090	19.3	1344	30.8	404	2	2	414	3	0	0	0
11	Өлзийт	1453	49.5	962	73.0	719	100	37	702	50	5	719	0
12	Сант	2110	12.1	1329	12.3	255	1	0	164	0	0	0	0
13	Тарагт	2144	30.8	1410	36.5	660	41	11	515	6	1	13	0
14	Төгрөг	1639	6.2	1038	8.1	102	0	0	84	0	0	138	0
15	Уянга	5781	24.2	3458	30.2	1400	18	2	1046	11	1	59	0
16	Хайрхандулаан	2204	21.1	1415	26.2	466	20	1	371	0	0	466	1
17	Хархорин НЭ					0	0	0	0	0	0	0	0
18	Хужирт	4176	8.8	2702	11.6	367	0	0	313	0	0	125	0
19	Бүсийн оношилгоо эмчилгээний төв					0	0	0	0	0	0	0	0
